

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2014 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар:	<i>“Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, Засгийн газрын тогтоол дугаар 90.</i> Төсөл, хөтөлбөрийн зорилго <i>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх замаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, цөлжилтөд өртсөн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино.</i>
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв /зээл/ буцалтгүй тусламж <i>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын төсөв, тусгай сан, иргэд, аж ахуй нэгж, байгууллагын хандив, гадаадын зээл, буцалтгүй тусламжаас бүрдүүлнэ.</i>
3.	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: <i>Хөтөлбөрт тусгасан тэргүүлэх чиглэл, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төр, иргэний нийгмийн байгууллагууд.</i> Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: <i>Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага</i> <i>Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага</i> <i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага</i> <i>Сангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага</i>

			• Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага • Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага • Эрдэс, баялаг, эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага • Аймаг, сумдын засаг дарга нар • Эрдэм шинжилгээ, судалгааны холбогдох байгууллага • Байгаль хамгаалах чиг үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллагууд • Олон улсын төсөл хөтөлбөрүүд						
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1. Байгууллагын чадавхийг бэхжүүлэх; Зорилт 2. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох; Зорилт 3. Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх; Зорилт 4. Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих; Зорилт 5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;						
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)							
		Үүнд:	Төсөв (Он)		Гүйцэтгэл			Хувь	
		Багц 1							
		Багц 2 (г.м)							

6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Цөлжилттэй тэмцэх үндэсний хороог хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган уялдуулан, зохицуулах чадавхитай болгох чиглэлээр шинэчлэн зохион байгуулж ажиллуулна. Хүрэх үр дүн 2: Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар цөлжилттэй тэмцэх талаар Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн бодлого, хөтөлбөр, төсөвт тусган үр дүнтэй хэрэгжүүлж тайлагнана. Хүрэх үр дүн 3: Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг иргэд, хувийн хэвшил, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө болон гадаад орон, олон улсын байгууллагын тусламж, дэмжлэгээр бүрдүүлнэ.	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл Төлөвлөгөөний гүйцэтгэл 1: - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 2012 оны 5-р сарын 17-ны өдөр батлагдсантай холбогдуулан Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны нэрийг Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний хороо болгон өөрчилж хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. - Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны ажлын албыг Засгийн газрын 168 тогтоолоор байгуулан ажиллуулж байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 2: 2013 оны байдлаар 14 аймаг цөлжилттэй тэмцэх хөтөлбөр, 8 аймаг дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний хороо холбогдох яамд, агентлагууд, орон нутгийн байгууллагуудаас жил бүрийн цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргуулан авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлж байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 3: 2013 онд Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт суулгасан ба тухайн жилд ШХА-ын “Цөлжилтийг сааруулах төсөл” болон НҮБХХ, ШХА-ын “Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент” төслүүд амжилттай хэрэгжиж дууссан байна. Одоогоор Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төсөл

	Хүрэх үр дүн 4: Боловсон хүчний чадавхийг сайжруулна.	амжилттай хэрэгжиж байна. • 2013 оны улсын төсөвт сумдын цаг уурын өртөөний барилга барих, газар доорхи усны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх, мэдээллийн сан үүсгэх, Газрын генератор болон дагалдах бусад тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах, Мод бэлтгэл, тээвэрлэлт, борлуулалтыг хянах, хяналтын видео систем зэрэг цөлжилтийн эрчмийг сааруулах чиглэлээр нийт 2,865 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг туссанаас 2013 оны төсвийн тодотголоор өөрчлөлт орж, 1,361 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлжээ. • 2014 онд дээрхи арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нийт 2,367 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэл 4: • ШХА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны төвийн эрхлэгч доктор А.Хауленбек НҮБ-ын ЦТК-ийн Шинжлэх ухаан технологийн хуралд оролцон Монгол улсын цөлжилтийн судалгаа, арга зүйн талаар мэдээлэл өгч бусад улс орнуудтай туршлага солилцсон. • Улаанбаатар хотноо “Заган ойн тогтвортой менежмент” олон улсын сургалт семинарыг НҮБ-ын ЦТК-ийн Ази, Номхон далайн орнуудыг хариуцсан нарийн бичгийн дарга, Солонгосын Ойн яам, Монгол-Солонгосын Ногоон Хэрэм төсөлтэй хамтран зохион байгуулсан. Тус сургалт, семинарт Төв Азийн орнуудын мэргэжилтэнүүдийг урьж орон нутгийн мэргэжилтнүүд ба холбогдох эрдэм шинжилгээний газруудын судлаач эрдэмтийг оролцуулан амжилттай зохион байгуулсан. • БСШУЯ-ны санхүүжилтээр, ШУА-ийн захиалгаар Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны төвд “Төв Монголын загвар нутгийн хүрээн дэх цөлжилтийн мониторингийн судалгаа” нэртэй суурь судалгааны ажил 2013 оноос эхлэн хэрэгжиж байна. • БНСУ-ын Донкукийн их сургуультай хамтран “Хуурай ба хагас хуурай бүс нутгийн
--	--	--

		цөлжилттэй тэмцэх нь” нэртэй төсөл Булган аймгийн Элсэн тасархай дахь “Цөлжилтийг сааруулах туршилт, судалгааны төв”-д үндсэн 4 чиглэлээр хэрэгжиж байна. • БНСУ-ын Ойн агентлаг, Геоэкологийн хүрээлэн хамтран “БНСУ болон Төв Азийн улс орнуудын ойн хамтын ажиллагаа” нэртэй олон улсын техникийн бага хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулсан. • ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн Элсэн тасархай дахь төвд Булган аймгийн Гурванбулаг, Рашаант, Архангай аймгийн Хашаат, Өвөрхангай аймгийн Бүрд зэрэг сумдын удирдлагууд, байгаль орчны байцаагч, газрын даамал, байгаль орчныг хамгаалагч нарт жил бүр “Цөлжилт, газрын доройтол, түүний шалтгаан нөхцөл, тэмцэх арга барил, технологиуд” нэртэй сургалт-семинарыг зохион байгуулдаг ба орон нутгийн иргэд идэвхитэй хамрагддаг болсон.
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, цөлжилтийг сааруулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна.	2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл Төлөвлөгөөний гүйцэтгэл 1: • Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийг 2012 оны 5-р сарын 17-ны өдөр УИХ-аар батлуулсан. • 2012 онд УИХ-ын хаврын чуулганаар Байгаль орчны багц хуулиудыг батлуулсан ба холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулсан болно. • Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлыг тогтоох журам болон зэрэглэлийн шалгуур үзүүлэлт, түүнийг тогтоох нэгдсэн аргачлалыг ШУА-Геоэкологийн хүрээлэн, Газарзүйн хүрээлэнгийн эрдэмтэд боловсруулж дууссан ба БОНХАЖ-ын сайдын тушаалаар батлуулахаар бэлтгэж байна. • Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалыг 2010 онд боловсруулсан. • УИХ-аар Байгаль орчны багц хуулиуд батлагдсантай холбогдуулан хуулиудыг сурталчлах ажил төлөвлөгөөний дагуу явагдсан.

		Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн хялбаршуулсан зурагт гарын авлагыг хэвлүүлэн төв орон нутгийн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.
	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Цөлжилтийн үндэсний нэгдсэн мэдээллийн сантай болно. Хүрэх үр дүн 2: Цөлжилт хүчтэй болон нэн хүчтэй илэрсэн бүс нутагт цөлжилт,	3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан Төлөвлөгөөний гүйцэтгэл 1: - Байгаль орчны мэдээллийн төв 2011-2012 ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнтэй хамтран Цвейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Цөлжилт, газрын доройтлын үнэлгээ, зураглал ба мэдээллийн сан” төслийг хэрэгжүүлсэн. - ШХА-ийн Цөлжилтийг сааруулах төслийн санхүүжилтээр Байгаль орчны мэдээллийн төв, ШУА-ын Гео-Экологийн хүрээлэн хамтран “Монгол орны цөлжилтийн атлас”-ыг боловсруулж 2 удаа хэвлүүлэн холбогдох байгууллага, их дээд сургууль болон хөдөө орон нутгийн байгууллагуудад хүргүүлсэн. - Монгол орны цөлжилтийн талаар мэдээллийн хуудас хэвлүүлэн олон нийтэд хүргүүлэх ажлыг хийж байна. - Цөлжилтийн мэдээллийн цахим санг бий болгож НҮБ-ын Конвенци болон бусад холбогдох хууль эрх зүйн мэдээлэл, судалгааны ажлуудын тайлан, цөлжилттэй тэмцэх чиглэлээр хэрэгжсэн төслүүдийн тайлан болон холбогдох мэдээлэл, фото болон видео мэдээлэлүүд зэрэг олон нийтэд зоиулсан мэдээлэлүүдийг оруулсан ба тогтмол шинэчилж байна. Мэдээлэлийн цахим хуудас: www.eic.mn/DLDBASE - Геоэкологийн хүрээлэн БОНХЯ-тай хамтран “Цөлжилтөд өртсөн бүс нутгийн биофизикийн судалгаа” нэртэй гэрээт ажлыг цөлжилт нэн хүчтэй, хүчтэй, дунд, сул зэрэг ангилалд багтсан нутгаар үнэлгээ хийн сааруулах арга хэмжээ, төлөвлөгөөний хамт боловсруулж байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 2: - Цаг уурын өртөө, харуулыг түшиглэн улсын хэмжээнд байгалийн бүс, газар зүйн

цөлжилтийн үйл явцыг судлах хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээ байгуулагдана. Хүрэх үр дүн 3: Цөлжилтийн судалгааны төвд цөлжилт, газрын доройтлыг сааруулах технологи, арга барилын мэдээллийн сан бүрдүүлэх.	байршлын онцлогыг харгалзан сум, багийн түвшинд сонгосон 1500 гаруй цэгт цөлжилтийн хяналт шинжилгээг хийж байна. • Геоэкологийн хүрээлэн цөлжилт, газрын доройтлыг экосистемийн иж бүрдлүүдийн хүрээнд авч үзэхээр хээрийн бүсийг төлөөлүүлэн Элсэн тасархай хэмээх газар, Газар тариалангийн бүс нутаг болон Дархан-Уул аймгийн Бүрэн толгой хэмээх газар урт хугацааны мониторингийн цэг бүхий 2 суурин газар байгуулан ажиллаж байна. Мөн энэ газар цөлжилтийг сааруулах ойн зурвасны тогтолцоо байгуулах болон дэвшилтэт технологиудыг туршин судалж байна. • ШУА-ийн Газар зүйн хүрээлэн “Олон жилийн цэвдгийн тархалт, горим, криоген үйл явцын судалгаа” суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсын системд тархсан мөнхцэвдэг болон криоген үйл явцын өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийхээр тус төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд 2008 онд 8-12м гүнтэй 21 цооног өрөвдсөн. 2010 онд ЦУОШГ-ын захиалгаар 10-15м гүнтэй 13 цооног, Япон улсын Хоккайдогийн их сургууль ба Глобал өөрчлөлтийн судалгааны хүрээлэнгийн санхүүжилттэй Дархадын хотгорт 5-35м гүнтэй 6 цооног тус тус өрөмдсөн байна. ЦУОШГ төлөвлөгөөний дагуу 2010 онд цэвдэгийн 13 цооног гарган ашиглаж байгаа бөгөөд 2012 онд 17 цооног өрөмдүүлж, хэмжлийн төхөөрөмжийг 2013 онд тавихаар ажилласан. 2013 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 50 орчим цооногт мөнх цэвдэгийн хувьсал өөрчлөлтийг тогтмол хэмжиж байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 3: • Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны төвийн үйл ажиллагааны хүрээнд цөлжилтийг сааруулах арга технологийн www.moncat.mn вэб сайт ажиллуулж байна. • “Дэлхийн хөрс, ус хамгаалах арга барил, технологи”-ийг манай орны нөхцөлд хэрэгжүүлэх зорилгоор “Монгол орны цөлжилтийг сааруулах чиглэлээр хийгдэж буй арга барил, технологиудыг бүртгэх, мөн
--	---

	Монголчуудын хөрс, ус хамгаалах уламжлалт арга, технологиудыг бүртгэлжүүлэх түгээн дэлгэрүүлэх” зорилгоор цахим хуудас нээн олон нийтэд нээлттэйгээр ажиллуулж байна. Эдгээр технологи, арга барилууд нь www.moncat.mn, www.drc.mn зэрэг цахим хуудсанд байрлуулсан.
4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Бүх шатны боловсролын түвшинд тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшүүлэх ажлын хүрээнд байгаль экологийг доройтуулж байгаа болон цөлжилтийг үүсгэж байгаа хүчин зүйл, хор уршгийн талаархи мэдлэгийг хүүхэд, залуучуудад эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	4-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан Төлөвлөгөөний гүйцэтгэл 1: • БШУЯ “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн агуулгыг ерөнхий боловсролын сургуулийн экологи, байгаль орчны сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна. 2014 оноос тус агуулгыг Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа болгон өргөжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн бүх хичээлийн агуулгад тусгах ажлыг хийж байна. • 2013 онд Насан туршийн боловсролын Гэгээрэл төвийн суралцагчдад “Тогтвортой хөгжлийн боловсрол”, Экологийн боловсролыг дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар дамжуулан олгож байна. 2013 онд Дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд улсын хэмжээнд нийт 11636 суралцагч хамрагдсан ба түвшингээр нь авч үзвэл: Бага боловсролд – 4156, суурь боловсролд – 3681, бүрэн дунд боловсролд – 3799 суралцагчид тус тус хамрагдсан. • Байгальд ээлтэй, байгаль орчны чиглэлээр сургалт явуулдаг эко-сургууль байгуулах төслийг Швейцарийн хөгжлийн агентлагийн Цөлжилтийг сааруулах төслийн санхүүжилт, БШУЯ-ны дэмжлэгээр 2 ТББ хэрэгжүүлж байна. 2011 онд Ховд, Баянхонгор, Говь-Алтай аймаг болон УБ хотод нийт 28 сургуульд эко-сургууль байсан бол 2012 онд 60 болж нэмэгдсэн. 2007-2012 оны хугацаанд нийтдээ 32 сургууль, 44 000 сурагч, 2088 багш эко сургуулиудад сурч, багшилж байна. 2013 оны байдлаар 60 гаруй сургууль ажиллаж байна.

	Хүрэх үр дүн 2: Цөлжилтийг нэмэгдүүлж байгаа шалтгаан, хүчин зүйл, үр дагаврын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, цөлжилттэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээллээр хангана.	• Цаашид эко-сургуулиудын үндэсний болон олон улсын сүлжээ байгуулахаар төлөвлөж байна. Экологийн болон тогтвортой хөгжлийн боловсролын агуулга, аргазүйг ЕБС-д түгээх, сурталчлах, уралдаан тэмцээн, аян зохион байгуулах, багш бэлтгэх, давтан бэлтгэх, багш нарын мэргэжил дээшлүүлэх, эдгээр үйл ажиллагааг бодлогоор дэмжих, сургууль, багш, олон нийтэд зориулсан сургалтын материал, гарын авлага, танилцуулга материал боловрсуулахаар төлөвлөж байна. • Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын экологийн мэдлэгийг сайжруулах зорилгоор аймаг бүр байгаль орчны чиглэлээр сургалт, суртчилгаа, өдөрлөг зэрэг олон үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. • Иргэний боловсрол хичээл заах бүх багшийг 3 удаа давтан бэлтгэж, хичээл заах багш нарт зориулсан гарын авлага, DVD материал бэлтгэн үнэ төлбөргүй түгээсэн. Мөн иргэний боловсрол хичээлийн 1-9 дүгээр ангийн сурах бичгийг шинээр зохион сурагчид ашиглаж байна. 2013-2014 оны хичээлийн жилд 10-12 дугаар ангийн иргэний боловсрол хичээлийн сурах бичгийг шинээр боловсруулах ажил хийгдэж байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 2: • НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн газраас жил бүрийн 6-р сарын 17-ны өдрийг Цөлжилттэй тэмцэх олон улсын өдөр болгон зарладаг бөгөөд энэ өдрийг угтсан ажлын хүрээнд цөлжилт, түүний шалтгаан, сөрөг үр дагаварын талаарх мэдээлэлүүдийг иргэд олон нийтэд зориулан өдөр тутмын сонингууд болон олон нийтийн мэдээлэлийн бусад хэрэгслүүд ашиглан хүргэх ажлыг тогтмол зохион байгуулан хийж байна. • 2014 оноос эхлэн орон нутгийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл ашиглан иргэд олон нийтэд зориулсан сургалтуудыг цөлжилттэй тэмцэх чиглэлээр явуулж байна. • Гэгээрэл төвүүд нь тогтвортой хөгжлийн боловсрол олгох өрхийн орлого нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулж байна. Эдгээр сургалтад
--	--	--

	Хүрэх үр дүн 3: Бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад шинжлэх ухаанд үндэслэсэн мэдээллийг хүргэх замаар зохистой шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.	нийт 61948 иргэн хамрагджээ. • “Цөлжилтийн мэдээллийн хуудас”-ыг бэлтгэж олон нийтэд тараах ажил хийгдэж байна. • Газрын харилцаа сэтгүүл болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэл түгээх ажлууд хийгдэж байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 3: • Экосистемийн системийн бүрдлүүдийн өөрчлөлтийг 2000-2010 онтой харьцуулахад сүүлийн 10 жилд хэрхэн хувьсан өөрчлөгдөж буйг харуулсан Монгол орны цөлжилтийн атлас хэмээх иж бүрэн судалгааны бүтээлийг шийдвэр гаргагчдад хүргүүлэх ажлыг хийсэн. • УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд болон бусад удирдах албан тушаалтнуудад зориулж “Цөлжилтийн мэдээллийн багц”-ыг бэлтгэж хүргүүлсэн.
	5-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Орон нутгийн түвшинд байгаль хамгаалал, байгалийн нөөц ашиглалтын менежментийг боловсронгуй болгох, бодит арга хэмжээг зохион байгуулах замаар цөлжилтийг сааруулна.	5-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан Төлөвлөгөөний гүйцэтгэл 1: • Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд 350,0 га талбайд тэжээлийн нэг ба олон наст ургамал тариалж, хадлангийн 950,8 га талбай, өвөлжөө, хаваржааны дэргэд бэлчээрийн 260,0 га талбайг хашиж, 1,5 сая га бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулсан. • Улсын төсвийн 14,8 тэрбум, иргэд, аж ахуйн нэгжийн 6,3 тэрбум нийт 21,3 тэрбум төгрөгөөр 85 услалтын системийг шинээр байгуулах болон сэргээн засварлаж төрийн болон орон нутгийн өмчийн 9,1 мянган га талбайг усалгаатай тариалангийн эргэлтэнд оруулсан. Нийт 46,5 мянган га талбайд усалгаатай газар тариалан эрхэлж байна. • Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлаас үзэхэд Атрын 3-р аян үндэсний хөтөлбөрийн хүрээнд өнжсөн буюу ашиглалтгүй байсан 255,0 мянган га талбайг эргэлтэд оруулсан. • ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн “Цөлжилтийг сааруулах арга технологиуд

		боловсруулж турших нь” сэдэвт төслийн зорилтын хүрээнд Монгол орны байгалийн бүс бүслүүрийн онцлогт зохицсон цөлжилтийг сааруулах технологи боловсруулах ажлыг хийж байна. Ойт хээрийн бүсийг төлөөлж Дархан Уул аймгийн Орхон сумын нутагт Бүрэнтолгойн усалгаатай талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах эхний туршилтыг хийсэн бөгөөд улиас, бургас, агч, гүйлс, хайлаас гэсэн 5 төрлийн 1500 мод суулгацаар тариалаад байна. Хээрийн бүсийг төлөөлж Булган аймгийн Рашаант сумын нутагт элсний нүүдлийг сааруулах хамгаалалтын ойн зурвас байгуулах арга технологийг туршихаар Тарнын голын дагуу Элсэн тасархай орчимд 25 га талбайг торлон хамгаалж тэнд хайлаас, бургасны суулгацаар ойн зурвас байгуулж, хүлэмж болон ил талбайд ховордсон модлог ургамлыг ургуулах туршилтыг хийгээд байна. • 2014 онд Улсын хэмжээнд гадаргын урсац хуримтлуулан ашиглах хөв цөөрмийн ажлыг үргэлжлүүлэн 6 хөв цөөрөм /3 нь улсын төсвөөр, 3 нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр/ байгуулсан. • Орон нутгийн иргэд, аж ахуй нэгж, ТББ-уудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал Өвөрхангай аймгийн Богд, Баруунбаян-улаан сумдын жишээн дээр “Малчдын бүлэгтэй хамтран заган ойг үржүүлэх” цоо шинэ тогтолцоог нэвтрүүлэн одоогийн байдлаар тус бүр 20000 бортогонд заган бортогтой тарьц ургуулж, жил бүр 10 га талбайг ойжуулах ажлуудыг хийж байна. • Монгол-Солонгосын хамтарсан “Ногоон хэрэм” төсөл Өмнөговь аймгийн Булган суманд 2010-2014 онд нийт 613 га талбайд заг тарих ажлыг хийгээд байгаа бөгөөд 2015 онд 400 га-д заг тарихаар төлөвлөөд байна. • Монгол орны говийн баянбүрдийн байршил, түүнийг нөхөн сэргээх судалгааны 2 үе шаттай ажлыг дуусгаж “Говийн баянбүрдийн байршил, түүнийг нөхөн сэргээх” зөвлөмж боловсруулсан. • Урьдчилсан байдлаар авсан 2013 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн мэдээгээр газарт учруулсан хохирлын хэмжээ 9.01 сая га талбай болж байгаа бөгөөд эдгээрийг дотор нь ангилбал
--	--	---

		тариалангийн газарт 39.0 мян.га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газарт 8.8 сая.га, хот тосгон бусад суурин газарт 6.5 мян.га, ойн сан бүхий газарт 153.7 мян.га, усны сан бүхий газарт 533.9 га, ухагдаж эвдэрсэн газар 10.4 мян.га талбай байна. • 2010 онд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэр болох Мухарын аманд нийт 30 га талбайд нийт 15,000 суулгац суулгасан. • Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг Экологи, уул уурхайн алба, ЗХ-ний ангийн хугацаат цэргийн албан хаагчид оролцож “Бурхантын хошуу”-ны 62 га талбайд 165000 ширхэг 1 сортын “Шинэс” тарьц суулгасан. • 2010-2013 оны хугацаанд Зэвсэгт хүчний ангийн байрлалд 81219 мянган ширхэг мод бут сөөг, орон нутагтай хамтарч 40874 мод бут сөөг 152040 м² буюу 15 гектар талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 2011-2013 онд холбогдох мэргэжлийн газруудтай хамтран Улаанбаатар хотын орчмын ногоон бүсэд нийт 880 га газарт ойн цэвэрлэгээ хийж, 380000 ширхэг суулгацаар 150 га газрыг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулсан. • Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Хөдөөгийн эрчим хүчний хангамжинд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах” төслийн хүрээнд 100-200 квт-ын хүчин чадалтай 4 нарны цахилгаан станц барьсан. • “100000 нарны гэр” хөтөлбөрийн хүрээнд 20 000 малчин өрхийг нарны цахилгаан эх үүсвэрээр хангасан. • АХБ-ны хөрөнгө оруулалтаар 20,2 кВ-ын хүчдэлийн системтэй нийтдээ 300 шахам км урт нэг фазын цахилгаан дамжуулах шинэ шугамын системийг Монгол орны нөхцөлд анх удаа барьж ашиглалтад оруулсан юм. • “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүч ашиглах” төслийн хүрээнд Нидерландын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 26816 малчин өрхийг 50 Вт-ын нарны цахилгаан үүсгүүрээр хангасан. • Төв аймгийн Зуунмод хотын 4-р дунд сургууль, Халдвартын эмнэлгийн өргөтгөл, “Ирээдүй” цэцэрлэгийг газрын гүний
--	--	--

	дулааны нөөцийг ашиглан дулааны эрчим хүчээр хангах ажлыг гүйцэтгэсэн. • БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах олон улсын тусламжийн үйл ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймгийн Мандах суманд 4 ширхэг салхины контроллер, 4 ширхэг нарны контроллертай, мөн тус үйлдвэрийн 150 кВА-ын хүчин чадалтай инвертер, 2 ширхэг насосны систем, 3 ширхэг холболтын хайрцаг, нарны мониторинг системээс бүрдэнэ. • Говийн бүсэд өндөр хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулах олон улсын хамтарсан судалгааны ажлын хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд, Тайшир, Дөргөн, Дундговь аймгийн Мандалговь, Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций сумдад судалгааны ажлыг хийж эхлээд байна. • Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг 2012 онд 8399 га, 2013 онд 8070 га, 2014 онд 6289 га нийт 22758 га талбайд гүйцэтгэсэн. • Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүх нийтээр мод тарих тухай зарлигын дагуу 2014 онд хавар, намрын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд 1368,6 мян. ширхэг модыг тарьж, уг ажилд 7105 аж ахуйн нэгж байгууллага, 150363 иргэн оролцсон байна. • Төлөвлөгөөний гүйцэтгэл 2: • Гадаадын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд 3000 гаруй малчдын бүлэг, ойн нөхөрлөл, хоршоо байгуулж тэдгээрийн үйл ажиллагаа, идэвхи санаачлагыг дэмжин сургалт, семинарыг тогтмол хийж байна. Бэлчээртэй холбоотой сургалт, семинарыг 50 гаруй удаа хийсэн байна. • 2014 онд 258 булгийн эхийг хашиж хамгаалан 71 гар худаг шинээр гаргаж, 108 гар худгийг сэргээн засварлаж, инженерийн хийцтэй 38 худаг завсарлаж ашиглагдахгүй байсан 80,0 мянган га бэлчээрийг ашиглах болсон. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2012 онд 221, 2013 онд 186 булаг
--	---

	шандыг хашиж хамгаалан тохижуулсан байна. • 2010-2013 онд бэлчээрийг усжуулах арга хэмжээний хүрээнд улсын төсөв, гадаад орон, ОУБ-с хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, орон нутгийн нийт 48 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөөр 3147 инженерийн хийцтэй худгийг аймаг дундын отрын бүс нутаг, 21 аймгийн сумдад шинээр барьж байгуулснаар 8,8 сая мал сүрэг, 4,7 сая га бэлчээрийн талбай, 15,7 мянган малчин өрхийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэв. Мөн улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгөөр 2000 орчим уст цэг тогтоох газар доорхи усны геофизикийн хайгуулын ажлыг зохион байгуулсан. Төлөвлөгөөний гүйцэтгэл 3: • 2013 онд нийт 3321,2 км авто замын ажил хийгдсэнээс 1824,7 км хатуу хучилттай авто замын ажил бүрэн дуусаж хөдөлгөөн нээсэн болно. Зам барилгын ажилд ашиглаж байгаа түгээмэл тархацтай нөөц ашигласны төлбөрийг тухайн оронд нутагт зохих журмын дагуу төлүүлж байна. • Авто замын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж байна. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөр, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох томоохон зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд 2013 онд нийт 1824 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад хүлээн аваад байна. Дахин боловсруулах Wirtgen технологийг ашиглалаа. Хуучин хучилтыг хуулж, газар дээр нь дахин боловсруулж дэвсдэг, хаягдал гаргадаггүй энэ технологи нь цаг хугацаа хэмнэхээс гадна байгаль орчинд ээлтэй технологи юм. Цаашид хүйтнээр дахин боловсруулах технологийн стандарт аргачлалыг боловсруулж, батлуулах шатанд байна. салбарын эрдэм шинжилгээ, инновацийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг ЗТЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн, батлуулж мөрдүүлэх шийдвэрийг гаргасан. • Хөрс бэхжүүлэгч Perma Zyme болон Nascon
--	--

	Хүрэх үр дүн 2: Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүд, байгаль хамгаалагчдын нөхөрлөлүүдэд байгалийн нөөцийг зохистой ашиглах эрх, үүргийн тогтолцоог бий болгох замаар	технологи (Duosolid)-ийн туршилт судалгааны ажил хийгдэж байна. Хөрс бэхжүүлэгч бодис (Duosolid, Polybond) хэрэглэн туршилтын авто замын хэсгийн барих ажлыг гүйцэтгэлээ. Төлөвлөгөөний гүйцэтгэл 4: - Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр манай оронд хуурайших, цөлжих явц эрчимшиж, байгаль цаг агаарын гаралтай аюлтай болон гамшигт үзэгдлийн давтагдал нэмэгдэж, гарах хохирлын хэмжээ өсөх хандлагатай байна. Эрсдлийг бууруулах чиглэлээр бид дараах арга хэмжээг авч байна. - Цөлжилтийн хяналт шинжилгээг 2011-2012 оноос эхлэн улсын хэмжээнд хийж эхэллээ. Бэлчээрийн ургамлын хяналт шинжилгээг жил бүр, хөрсний чанарын анхан шатны үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлыг 5 жилд нэг удаа хийнэ. Өөрөөр 2015 оноос цөлжилтийн үнэлгээ хийхэд хөрсний чанарын үзүүлэлтүүдийг харгалзан цөлжилтийг сааруулах чиглэлээр бүс нутгийн хэмжээнд авах арга хэмжээг нарийвчлах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. - Хүчтэй цасан ба шороон шуурга, үер, аадар тунадас зэрэг байгаль цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед урьдчилан сэргийлэх мэдээг байгууллагын цахим хуудас, гар утасны аппликейшн, радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдүүдээс гадна төв, орон нутгийн онцгой байдлын албадын шугамаар зарлуулж сэрэмжлүүлэх арга хэмжээ авч байна. - Гангийн нөлөөг бууруулах, зарим тохиолдолд хүн хүч, газрын техник хүрч чадахгүй газар гарсан түймрийг унтраах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж байна.
--	---	---

	байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Хүрэх үр дүн 3: Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр доройтолд орсон газар нутгийг нөхөн сэргээхэд байгалийн нөөц, баялаг ашиглаах аргаар өдөр үнэ өсөх оролцоог нэмэгдүүлж “нөөц ашиглагч төлөх” зарчмыг нэвтрүүлнэ;	
--	---	--

	Хүрэх үр дүн 4: Цөлжилтөд өртсөн бүс нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй нягт уялдуулан, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, амьдрах орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг үүрэгжүүлж байна.	
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал, дутагдалтай талуудыг энд бичнэ. Хөтөлбөрт нийтдээ 78 арга хэмжээ тусгагдсан байна. Эдгээр арга хэмжээнүүдийн 34 нь сайн, 27 нь дунд, 17 нь хангалтгүй хэрэгжсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарсан ололттой зүйлс: • Хууль эрх зүйн орчин боловсронгуй болсон. • Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны ажлын албыг бэхжүүлэх ажил хийгдэж байна. • Олон нийтэд цөлжилтийн үр дагаварын талаар байнгын мэдээлэл өдөр тутмын хэвлэл мэдээлэл болон цахим мэдээллийн хэрэгслүүдээр өгч байна. • Цөлжилт, түүний шалтгаан нөхцлүүд болон бусад мэдээлэлүүдийг багтаасан мэдээлэлийн цахим сан бий болгон тогтмол ажиллуулж байгаа нь чухал ач холбогдолтой. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дутагдалтай зүйлс: • Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээр тодорхой ажил хийгдэж байгаа боловч Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар амжилттай ажиллаж буй гадаад орнуудын

			туршлагатай орон нутгийн мэргэжилтнүүдийг танилцуулах хөрөнгө санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байна. - Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг санхүү, мөнгөний талаар дэмжих эрх зүйн орчин бүрдээгүй зэрэг дутагдалтай байна. - Хөрөнгө санхүү дутагдалтай, хүрэлцээгүй байдгаас Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг бүрэн хэмжээнд хэрэгжүүлж чадахгүй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс: - Цөлжилт, газрын доройтолд өртөж буй бүс нутгийн холбогдох судалгааг бодлогоор, хөрөнгө гарган хийх шаардлагатай байна. - Аймгуудын цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах ажлыг зохионо байгуулах					
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		...%	5	...%	...%	...%		
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ					
			...%					